



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2026/136/НА-СТА-ТШ

Цахим хуудас:
www.audit.mn

Баянхонгор хот
2026 оны 02 дүгээр сарын 25

2026

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Аудитор: Д.Даваадорж

Утас: 90119422 Цахим хаяг: Davaadorjd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	17
Аудитаар нийт 324.3 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 324.3 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хүргүүлсэн	17
Нийт илрүүлсэн 324.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 2,382.3 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө	17
5.1 Албан шаардлага	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18
7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХГБХХЕГ	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж, ахуйн тооцоот үйлдвэрийн газар



БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМ
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА
А.БАТАА ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2026.02.25 № 2/622

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өмнөх оны санхүүгийн тайланд бүртгэлтэй байсан 76,814.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлээс Баянцагаан сумын ЗДТГ-аас авах 3,115.0 мянган төгрөгийн авлага бүрэн барагдсан бөгөөд "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-тай холбоотой авлагын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

Аймгийн онцгой комиссын 2025 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрийн дагуу 500 кг-аар боосон 203 боодол, 25 кг-аар боосон 1,954 боодол өвсийг нийт 76,126.0 мянган төгрөгөөр хорогдол тооцож акталсан нь бараа материалын дансны бууралтад голлон нөлөөлсөн байна.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2025 онд орон нутгийн санхүүжилтээр 400,894.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 10,206.6 мянган төгрөг нийт 411,101.0

мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 405,756.4 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 5,344.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 83.6 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,105,156,705.00	725,168,602.07
33	АВЛАГА	76,814,500.00	100,822,260.07
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	122,760.07
335	Бусад авлага	76,814,500.00	100,699,500.00
3351	Байгууллагаас авах авлага	3,115,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	73,699,500.00	100,699,500.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,028,342,205.00	624,346,342.00
354	Хангамжийн материал	1,028,342,205.00	624,346,342.00
35410	Бичиг хэргийн материал	2,750,600.00	2,961,600.00
35420	Аж ахуйн материал	7,527,400.00	13,709,987.00
35440	Түлш, шатах тослох материал	500,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	1,017,564,205.00	607,674,755.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	450,945,911.39	951,348,264.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	450,945,911.39	951,348,264.30
392	Биет хөрөнгө	378,815,111.39	879,217,464.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	91,391,450.00	799,193,728.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,923,036.66	-7,350,861.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	340,024,914.30	140,024,914.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-147,579,830.43	-91,825,649.39
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,409,386.00	25,747,386.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,465,036.40	-18,578,799.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,793,459.00	1,793,459.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,422,625.74	-1,618,459.15
39214	Бусад үндсэн хөрөнгө	118,150,133.60	46,583,043.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11,563,702.28	-14,751,297.14
393	Биет бус хөрөнгө	72,130,800.00	72,130,800.00
39301	Програм хангамж	836,000.00	836,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-836,000.00	-836,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	72,130,800.00	72,130,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,556,102,616.39	1,676,516,866.37
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	225,547,114.11	683,637.32
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	225,547,114.11	683,637.32
413	Өглөг	225,547,114.11	683,637.32
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,631,489.11	583,637.32
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	200,000,000.00	100,000.00
4136	Бусад өглөг	14,915,625.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	14,915,625.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,330,555,502.28	1,675,833,229.05
51	Засгийн газрын хувь оролцоо	1,330,555,502.28	1,675,833,229.05
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	211,388,886.00	211,388,886.00
51101	Өмч: - төрийн	211,388,886.00	211,388,886.00

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

512	Хуримтлагдсан үр дүн	1,119,166,616.28	1,464,444,343.05
51210	Өмнөх үеийн үр дүн	1,119,166,616.28	1,316,051,616.28
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	148,392,726.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,556,102,616.39	1,676,516,866.37

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,218,775,200.00	1,228,777,680.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	591,616,100.00	825,106,405.00
120	Нийтлэг татварын бус орлого	591,616,100.00	825,106,405.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	526,096,000.00	10,206,640.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,600,000.00	10,206,640.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	515,496,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	627,159,100.00	403,671,275.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	322,803,900.00	2,776,875.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	322,803,900.00	2,776,875.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	304,355,200.00	400,894,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	304,355,200.00	400,894,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	879,177,838.11	622,048,600.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	879,177,838.11	622,048,600.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	875,880,090.11	613,927,051.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	269,908,454.86	310,080,573.35
210101	Үндсэн цалин	191,383,337.46	164,650,503.89
210102	Нэмэгдэл	59,246,561.96	120,457,305.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,125,439.76	15,946,363.64
210104	Урамшуулал	5,153,115.68	9,026,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,292,434.25	42,872,880.97
210201	Тэтгэврийн даатгал	30,292,434.25	29,454,480.97
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,354,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,677,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,677,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	6,709,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,900,777.00	10,000,000.00
210301	Гэрэл, цахилгаан	7,900,777.00	10,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	37,851,700.00	95,421,025.00
210401	Бичиг хэрэг	2,689,900.00	3,316,000.00
210402	Тээвэр, шатахуун	12,220,000.00	10,719,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514,800.00	386,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,107,000.00	4,873,725.00
210408	Бараа материал акталсны зардал	16,320,000.00	76,126,000.00
2105	Нормативт зардал	00.00	7,150,000.00



Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	7,150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	13,956,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	856,000.00
210604	Урсгал засвар	00.00	13,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450,584,375.00	50,058,875.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	450,252,375.00	50,058,875.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	00.00
210807	Газрын төлбөр	200,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	79,342,349.00	84,387,697.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,407,680.00	28,253,475.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	59,934,669.00	56,134,222.34
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,297,748.00	8,121,548.82
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,297,748.00	8,121,548.82
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,297,748.00	8,121,548.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	339,597,361.89	606,729,079.52
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	458,336,352.75
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	458,336,352.75
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-458,336,352.75
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	339,597,361.89	148,392,726.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	637,759,100.00	413,877,915.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,600,000.00	10,206,640.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,600,000.00	10,206,640.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,600,000.00	10,206,640.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,600,000.00	10,206,640.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	627,159,100.00	403,671,275.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	322,803,900.00	2,776,875.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	322,803,900.00	2,776,875.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	304,355,200.00	400,894,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	304,355,200.00	400,894,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	637,759,100.00	413,877,915.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	637,759,100.00	413,877,915.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	634,461,352.00	405,756,366.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257,395,000.00	321,191,766.18
210101	Үндсэн цалин	158,125,000.00	175,761,696.72
210102	Нэмэгдэл	75,748,500.00	120,457,305.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,125,439.76	15,946,363.64



Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	569,883.98	00.00	569,883.98
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	501,360,663.05	00.00	713,137,549.05
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	216,238,384.71	00.00	216,238,384.71
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	00.00	1,119,166,616.28	00.00	1,330,555,502.28
D01	2025 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	00.00	1,119,166,616.28	00.00	1,330,555,502.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	196,885,000.00	00.00	196,885,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,388,886.00	00.00	1,316,051,616.28	00.00	1,527,440,502.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	148,392,726.77	00.00	148,392,726.77
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	00.00	1,464,444,343.05	00.00	1,675,833,229.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Тайлант оны			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	406,395,500.00	395,756,366.18	10,639,133.82	97.38
Орон нутгийн төсвөөс	406,395,500.00	395,756,366.18	10,639,133.82	97.38
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	416,395,500.00	405,756,366.18	10,639,133.82	97.44
Ажиллагчидтай холбогдсон зардал	369,222,300.00	363,124,066.18	6,098,233.82	98.35
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	327,290,000.00	321,191,766.18	6,098,233.82	98.14
Үндсэн цалин	179,784,000.00	175,761,696.72	4,022,303.28	97.76



Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Нэмэгдэл	119,205,400.00	120,457,305.82	(1,251,905.82)	101.05
Унаа хоолны хөнгөлөлт	16,315,000.00	15,946,363.64	368,636.36	97.74
Урамшуулал	11,985,600.00	9,026,400.00	2,959,200.00	75.31
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,932,300.00	41,932,300.00	-	100.00
Тэтгэврийн даатгал	28,513,900.00	28,513,900.00	-	100.00
Тэтгэмжийн даатгал	3,354,600.00	3,354,600.00	-	100.00
ҮОМШӨ-ний даатгал	1,677,300.00	1,677,300.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	1,677,300.00	1,677,300.00	-	100.00
Эрүүл мэндийн даатгал	6,709,200.00	6,709,200.00	-	100.00
Бараа ,үйлчилгээний урсгал зардал	46,673,200.00	42,632,300.00	4,040,900.00	91.34
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
Гэрэл, цахилгаан	10,000,000.00	10,000,000.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	15,734,000.00	13,032,300.00	2,701,700.00	82.83
Бичиг хэрэг	3,000,000.00	2,427,000.00	573,000.00	80.90
Тээвэр, шатахуун	12,219,200.00	10,219,200.00	2,000,000.00	83.63
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514,800.00	386,100.00	128,700.00	75.00
Нормативт зардал	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	15,600,000.00	15,600,000.00	-	100.00
Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	2,500,000.00	-	100.00
Урсгал засвар	13,100,000.00	13,100,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,839,200.00	1,500,000.00	1,339,200.00	52.83
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,973,200.00	1,500,000.00	473,200.00	76.02
Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	00.00	66,000.00	-
Газрын төлбөр	800,000.00	00.00	800,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500000.00	0.00	500,000.00	-
Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	00.00	500,000.00	-
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	500,000.00	00.00	500,000.00	-
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	416,395,500.00	405,756,366.18	10,639,133.82	97.44
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00

2.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /



Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,776,875.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,776,875.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,776,875.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,776,875.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,776,875.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2776875.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,776,875.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,776,875.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь “Мод тарьц, суулгацыг үржүүлж, аймгийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх” эрхэм зорилготой, 2025 онд 16 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд 100 мянгаас доошгүй тарьц суулгацыг үржүүлж, нэмэгдүүлсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянхонгор аймаг дахь Сум дундын ойн анги нь Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Ойн тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Гамшгаас хамгаалах тухай, Нийгмийн даатгалын тухай, татварын баг хулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.


Дотоод аудитын чиг үүргийг Аймгийн ЗДТГ-ын Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг бөгөөд 2025 онд Баян-өсөх агро ОНӨААТҮГ-т шилжүүлэхтэй холбогдуулан бараа материалын “малын тэжээл” дансанд хяналт баталгаажуулсан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь



холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь 2025 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 120,414.2 мянган төгрөг буюу 7,7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	76,814.5	100,822.3	24,007.8
Бараа материал	1,028,342.2	624,346.3	(403,995.9)
Үндсэн хөрөнгө	661,736.1	1,086,309.3	424,573.2
Хуримтлагдсан элэгдэл	(210,790.2)	(134,961.1)	75,829.2
Нийт хөрөнгө	1,556,102.6	1,676,516.9	120,414.2
Өр төлбөр	225,547.1	683.6	(224,863.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,330,555.5	1,675,833.2	345,277.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,556,102.6	1,676,516.9	120,414.2

Эх сурвалж: Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан

Авлагын дансны үлдэгдэл 100,822.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 24,007.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өмнөх оны санхүүгийн тайланд бүртгэлтэй байсан 76,814.5 мянган төгрөгийн авлагын үлдэгдлээс Баянцагаан сумын ЗДТГ-аас авах 3,115.0 мянган төгрөгийн авлага бүрэн барагдсан бөгөөд “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-тай холбоотой авлагын дүнд өөрчлөлт ороогүй байна.

“Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-тай холбоотой авлагыг барагдуулах асуудлаар Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь 2025 онд гэрээгээр баталгаажсан 12 хариуцагчид холбогдох 12,580.0 мянган төгрөгийг хариуцагч тус бүрээр Баянхонгор аймаг дахь сум дундын анхан шатны шүүхийн эврүүлэн зуучлагчид нэхэмжлэл гаргасан байна.

Гэвч “Хонгор шинэ агро” ОНӨААТҮГ-ыг татан буулгах тухай аймгийн ИТХ-ын тэгүүлэгчдийн 2020 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн 88 дугаар тогтоолд тус байгууллагын өр, авлагыг Сум дундын ойн ангид шилжүүлэх талаар ямар нэгэн заалт тусгагдаагүй тул авлагыг нэхэмжлэх хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж, шүүх нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

Тайлант онд, 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр 1 иргэнд 27,000.0 мянган төгрөгийн нэг настай тарьц суулгацыг зээлээр борлуулж, авлагаар бүртгэсэн нь авлага дансны өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн байна

Уг авлага нь 2025 оны 12 дугаар сард төлөгдөхөөр тохиролцсон хэдий ч хугацаандаа төлөгдөөгүй тул байгууллага 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр

Баянхонгор аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Үүний үр дүнд 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 303/Ш32026/00452 дугаар шүүгчийн захирамжаар тухайн иргэнээс авлагыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс өмнө төлүүлэх шийдвэр гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл тайлант оны эцэст 624,346.3 мянган төгрөг болж, өмнөх үеэс 403,995.9 мянган төгрөгөөр буурсан байна. Тус байгууллага төсвийн хөрөнгөөр 18,923.2 мянга, үнэ төлбөргүй 62,972.6 мянга, нийт төгрөг 81,895.8 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч 146,819.9 мянган төгрөгийн бараа материалыг өөрийн үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/61 дугаар тогтоолоор “Баян-Өсөх агро” ОНӨААТҮГ-т 248,377.0 мянган төгрөгийн бараа материалыг, мөн аймгийн Онцгой комиссын 2025 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар хурлын шийдвэрээр Баянхонгор сумын ЗДТГ-т 14,568.7 мянган төгрөгийн бараа материалыг тус тус үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

Түүнчлэн аймгийн Онцгой комиссын дээрх шийдвэрийн дагуу 500 кг-аар боосон 203 боодол, 25 кг-аар боосон 1,954 боодол өвсийг нийт 76,126.0 мянган төгрөгөөр хорогдол тооцож акталсан нь бараа материалын дансны бууралтад голлон нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,086,309.3 мянган төгрөг болж 424,573.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 10/77 дугаар тогтоолоор 751,927.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, мөн аймгийн ИТХ-ын хуралдааны 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/61 дугаар тогтоолоор “Баян-Өсөх агро” ОНӨААТҮГ-т 325,945.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь үндсэн хөрөнгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлжээ. Мөн дээрх хурлын тогтоолоор бусад үндсэн хөрөнгийн бүртгэлд байсан 1,409.0 мянган төгрөгийн модыг байгууллагын бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 683.6 мянган төгрөг болж өмнөх оноос 224,863.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Өмнөх онд үүссэн цалин болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан ХХОАТ, хоёр ажилтнаас илүү суутгасан НДШ-ийн нийт 10,631.4 мянган төгрөгийн өглөгийг тайлант онд бүрэн төлсөн байна.

Харин өмнөх онд Баянхонгор сумын ЗДТГ-аас авсан 14,915.6 мянган төгрөгийн хивэг, тэжээлийг зээлээр авч өглөгөөр бүртгэсэн байсан бөгөөд тайлант онд АОК-ын шийдвэрээр Баянхонгор сумын ЗДТГ-т бараа материалыг шилжүүлж өглөгөө хаасан байна. Мөн техник тоног төхөөрөмжтэй холбоотой 200,000.0 мянган төгрөгийн өглөгийг “Баян-Өсөх Агро” ОНӨААТҮГ-т тоног төхөөрөмжийн хамт шилжүүлж, нягтлан бодох бүртгэлд тусган хаасан нь өглөгийн дансны бууралтад голлон нөлөөлсөн байна.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ыг санхүүгийн тайлангийн Acolous нэртэй программыг ашиглаж байгаа бөгөөд “39301 Программ хангамж” дансанд бүртгэсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 395,602.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 395,602.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 36,099.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 431,701.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийг нэг удаа тодотгол хийж 416,395.5 мянган төгрөгөөр баталж анхны төсвийг 15,306.3 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд орон нутгийн санхүүжилтээр 400,894.4 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 10,206.6 мянган төгрөг нийт 411,101.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс урсгал үйл ажиллагаанд 405,756.4 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 5,344.7 мянган төгрөгийг төвөлрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 405,756.4 мянган төгрөг буюу 97.4 хувьтай байна.

Цалин болон нэмэгдэл урамшууллын зардлаас 6,098.2 мянга, бараа үйлчилгээний зардлаас 4,040.9 мянга, урсгал шилжүүлгийн зардлаас 500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулаагүй нь зардлын гүйцэтгэл бүрэн биелэхгүй үлдэхэд нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	415,895.5	405,756.4	10,139.1	97.5
2	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	500.0	00	500.0	00
	Нийт дүн	416,395.5	405,756.4	10,639.1	97.4

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үр дүнг нэгтгэв. Үүнд:

1. Бүтэц, орон тооны хязгаарыг Сум дундын ойн ангийн даргын 2025 оны А/01 тушаалаар 16 орон тоо баталж Аймгийн ИТХ-ын 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 8/45 дугаар тогтоолоор 6 орон тоог цомхотгол хийсэн байна. Үүнд: Ахлах мэргэжилтэн 1, архив бичиг хэргийн эрхлэгч 1, нярав 1, механикч 1, ойжуулагч 2 нийт 6 орон тоо багтсан байна.
2. Хоолны хөнгөлөлт нэг өдөрт 5.0 мянган төгрөгөөр тооцож хоолны хөнгөлөлтөд 15,946.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 15,946.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 2,776.9 мянган төгрөгийн өвс тэжээлийн орлого орж ирснийг орон нутгийн төсвийн дансанд 2,776.9 мянган төвлөрүүлсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь 2025 онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2025 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн дарга А.Батаа, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч А.Нямхүү нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны батлагдсан төсвийн нийт зардлын 416,395.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,163.9 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 2,706.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж батлагдсан төсвийн 97.4 хувийг зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 13,100.0 мянган төгрөгийн 1 гүйлгээ, орлогын 400,894.4 мянган төгрөгийн 12 гүйлгээ мэдээлэхээс шилэн дансны цахим хуудсанд бүрэн байршуулсан байна. Мөн төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 45,155.4 мянган төгрөгийн 10 шийдвэрийг мэдээлэхээс бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт



4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг ажлыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Даваадорж гүйцэтгэж, нийт 28,991.8 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэн бөгөөд хэрэгжилт бүрэн хангагдсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	3,115.0	1	3,115.0	100
Албан шаардлага	2	25,876.8	2	25,876.8	100
Нийт дүн	3	28,991.8	3	28,991.8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баянхонгор аймгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар тус байгууллагын авлагын дансанд бүртгэсэн "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-аас шилжин ирсэн 73,699.5 мянган төгрөгийн авлагын барагдуулах асуудлыг онцгойлон анхаарч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 583,6 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

Тайлант онд цалингаас суутгасан ХХОАТ-ыг 583,6 мянган төгрөгөөр дутуу шилжүүлсэн байхад өглөгөөр бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Аудитаар нийт 324.3 мянган төгрөгийн 2 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах 324.3 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн 324.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшингээс 2,382.3 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Нягтлан бодогч 9 дүгээр сарын цалин бодохдоо нэг ажилтны бодогдсон 324.3 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын санд мэдээлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32.2.2."орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэсэнтэй нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Дутуу мэдээлсэн цалинг нөхөн мэдээлэн зөрчлийг арилгаж цаашид зөрчлийг давтан гаргахгүй байж холбогдох хууль журмыг мөрдөн ажиллах албан шаардлагыг хүргүүлэв.

5.1.2 Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 3 төрлийн 130,600м² газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 2 газрын 106,557м² газрыг байгууллагын баланс-д бүртгэж орлого аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Газрын харилцаа, хот байгуулалтын газартай тооцоо нийлж зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд цалингаас суутгасан ХХОАТ-ыг 583,6 мянган төгрөгөөр дутуу шилжүүлсэн байхад өглөгөөр бүртгээгүй байна.	1	586.6	1	586.6			1	586.6				
дүн	1	586.6					1	586.6	0	0	0	0

7. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогч 9 сарын цалин бодохдоо нэг ажилтны бодогдсон 324.3 мянган төгрөгийн цалинг нийгмийн даатгалын санд мэдээлээгүй байна.	1	324.3			1	324.3		
Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 3 төрлийн 130,600м ² газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 2 газрын 106,557м ² газрыг байгууллагын баланс-д бүртгэж орлого аваагүй байна	1	0			1	0		
Нийт дүн	2	324.3			1	324.3		

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.





БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 132/Н057/МСС/БНА-2026-
-136/МА-СТӨ-7445.

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодогч 9 сарын цалин бодохдоо нэг ажилтны бодогдсон 324,285 (Гурван зуун хорин дөрвөн мянга хоёр зуун наян тав) төгрөгийн цалинг нийгмийн даатгалын санд мэдээлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32.2.2."орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийгмийн даатгалын санд дутуу мэдээлсэн 324,285 (Гурван зуун хорин дөрвөн мянга хоёр зуун наян тав) төгрөгийн цалинг нөхөн мэдээлж зөрчлийг арилган

6426030386

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дугаар сарын 15-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн дарга А.Батаа, нягтлан бодогч А.Нямхүү нарт даалгав^{2,3}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

АУДИТОР:




Д.ДАВААДОРЖ

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 136/А05710.55/БМА-2026-
- 136-СТА-ТМБ. Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын эзэмших эрхийн гэрчилгээтэй 3 төрлийн 130,600м² газар байгааг төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ, (egazar.gov.mn)-тэй тулган шалгахад 2 газрын 106,557м² газрыг байгууллагын баланс-д бүртгэж орлого аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт "Үнэн зөв байх", УСОУНББ 17 – Үндсэн хөрөнгө 17.12-т Үндсэн хөрөнгийн бүртгэлд эзэмшиж буй газар, барилга, байгууламжийн хэмжээ, үнэлгээг үнэн зөв тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Газрын харилцаа, хот байгуулалтын газартай тооцоо нийлж зөрчлийг арилган хэрэгжилтийг FAS системд оруулж, нотлох баримтыг 2026 оны 06 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх¹

¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

8426630390

/documents/2026 он/1. бичиг
хэрэг/тоот/4. албан шаардлага 2026.docx

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн дарга А.Батаа, нягтлан бодогч А.Нямхүү нарт даалгав^{2,3}.


АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АУДИТОР:

Д.ДАВААДОРЖ



² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно